



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 0/695

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 12 дугаар
цэцэрлэгийн биет бус хөрөнгө
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 420,000.0 /дөрвөн зуун хорин мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэг /Ж.Жавзан /-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 420,000.0 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэг /Ж.Жавзан /-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 24 өдрийн 0/16 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр |
|--|------------------------------|---------------|-------------|------------|-------------|-------------------|--------------------|--------------|-------------------|-------------------------------|
| 1 | Хөрөнгийн программ /няравын/ | 8 | Ш | 1 | 240,000.00 | 240,000.00 | - | - | ашиглах боломжгүй | устгах |
| 2 | Өмчийн программ | 10 | Ш | 1 | 180,000.00 | 180,000.00 | | | | устгах |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | 420,000.00 | | | | |
| Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | | | | | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | | | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | |
| НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/ | | | | | | | | | | |